

Монгол, хятад хэлний “цай” болон “茶 [cha]”
хэмээх үгийн утга, хувьсал

Гөрөөчингийн ЦОГЗОЛМАА*

Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Гадаад харилцааны алба

ҮНДЭС

Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль, Хятад хэлний тэнхим

Received: 30 August 2025 / **Accepted:** 17 September 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Монгол, хятад хэлний “цай” / “茶” нь ижил гаралтай, анх утга нэгтэй байсан хэдий ч хэрэглээний явцад хоёр үндэстний түүх, соёлын ялгаанаас шалтгаалан утга, хэрэглээ нь өргөжиж, тус тусын өвөрмөц соёлын онцлогийг шингээсэн хэл зүйн болон утга зүй хөгжлийн сууриа тавьжээ. Мөн “茶” / “цай” гэдэг үгээс олон төрлийн үг гарч, утга хэлбэр нь тус тусад нь хөгжсөн байдаг. Үүгээр дамжуулан хоёр ард түмний амьдралын хэв маяг, сэтгэлгээ, үнэт зүйлсийг илтгэх соёлын ялгааг тодорхойлон харж болох юм.

Түлхүүр үгс: Монгол, хятад, хэл, соёл, “Цай”, “茶”, утга, хувьсал

The Meaning and Evolution of the
Mongolian Word 'Tsai' and the Chinese Word 'Cha'

TSOGZOLMAA Guruuchin

Foreign Affairs Office, Mongolian National University of Education,
Ulaanbaatar, Mongolia

WEN DU SU

Department of Chinese Language, School of Social Sciences and Humanities,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Abstract: The Mongolian and Chinese words "cai" originally came from the same word, but over the course of usage, the meaning of the word expanded and developed into the meaning of the word expanded and developed into polyseme due to the cultural differences between the two nations.

The aim is to highlight the knowledge, customs, and values of the two nations through the group of words related to tea that have emerged in the vocabulary of both languages. According to research,

* © Author(s), 2025, Email: tsogzolmaa@msue.edu.mn



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

since the Chinese were the first to cultivate tea, they have words for each stage of the tea leaf's growth, while Mongolians are tea consumers, so they have different words for different types of tea.

Key words: Mongolia, China, Language, Culture, “Tea”, “茶”, Meaning, Evolution

1. Удиртгал

Хятад орон бол цайны өлгий нутаг юм. Түүхэн сурвалжид дөрвөн мянга долоон зуун жилийн өмнө Шэньнуны¹ үес цайны эмийн чанарыг таньж, эмт ургамлын тэргүүн байранд цайг жагсаасан байдаг.

“Монголын нууц товчоо”, “Их Юань улсын хууль цаазын бичиг”, “Идээ ундааны жинхэнэ товч”, “Монголын зан аалийн үйлвэр” зэрэг түүхэн сурвалжид үндэслэн авч үзвээс, Монголчууд эртнээс нааш цайг эрхэмлэн хэрэглэж ирсэн нь илэрхий бөгөөд Хүлэг хаан (1281-1311)-ы үед хааны ордон болон Монголын дээд язгууртнуудын дунд цай уух заншил байсан нь тодорхой байна.

Монголчуудын шахмал цай (хятад гаралтай цай) уух түүх нь Сүн (960-1279 он), Ляо улс (907-1125)-ын үеэс эхтэй хэмээн тэмдэглэгдсэн байдаг. Судлаачдын үзэж байгаагаар түүний үндэс нь Сүн улс Төвөд нутаг болон хойд нүүдэлчидтэй идэвхтэй худалдаа хийж, тусгайлан “Цай, морины хэлтэс”² хэмээх агентлаг байгуулсан явдалтай холбоотой ажээ (Янь Пин, 1994: Т13).

Мин улсын үед цай, морины худалдаа арилжаа сайтар хөгжиж, Чин улсын үед Монголын бүс нутагт цайны эрэлт нэмэгдэж, ард иргэд худалдан авах боломжтой болсон тул цай нь монголчуудын гол ундаа болон өргөн дэлгэрчээ.

Ийнхүү цай нь монголчуудын “тансаг таван идээ”³, хятадуудын “өглөө хаалга нээх долоон зүйл”⁴-ийн нэг болж, өдөр тутмын хэрэглээний чухал хэсэг болжээ. Үүний нөлөөгөөр цайтай холбоотой үг хэллэг, зан үйл, соёл улам бүр хөгжиж, цайны тухай ном бүтээл олноор туурвих болжээ. Цайны соёлыг түгээн дэлгэрүүлсэн эртний судлаачдын бүтээл хожмын эрдэмтэн судлаачдын сонирхлыг татсаар байгаа бөгөөд энэ чиглэлийн судалгааны өгүүллүүд жилээс жилд нэмэгдсээр байна.

2. Судалгааны арга зүй

Хоёр ард түмний хэл, соёл сэтгэлгээний онцлогийг цай хэмээх үгээр дамжуулан утга, бэлгэдэл, хувьслыг зэрэгцүүлэн судалж, ижил, ялгаатай талыг харьцуулан үзүүлэв.

3. Хятад хэлэн дэх цайны нэршлүүд

Хятадаас үүсэлтэй цай нь анхандаа өнөөгийн 茶 [cha] гэсэн дуудлага, бичлэгтэй байгаагүй бөгөөд түүхийн явцад нэршил нь өөрчлөгдөн хөгжиж ирсэн байна. Хүснэгтлэн үзүүлбэл:

Хүснэгт 1. “茶” [cha] үгийн дуудлага болон бичлэгийн хувьсал

д/д	茶 Cha	Утга
-----	-------	------

¹ Хятадын соёл иргэншлийн түүхэнд Шэньнун-ыг газар тариалан, эм танг үндэслэсэн гэж үздэг.

² www.TibetOnline.cn


³ Ус, цай, хужир, сүү, давс.

⁴ 柴米油盐酱醋茶. Түлээ, будаа, тос, давс, жан, цуу, цай.

1	Jia 𣎵 ⁵	苦茶 (<i>ku tu</i>) хэмээх гашуун цай
2	She 𣎵 ⁶	Ханзны анхны утга нь “анхилуун өвс”
3	Ming 茗	Тан улсын “ <i>Цайны судар</i> ”-т залуу цайны навч, нарийн чанар цай, ялангуяа хоёр дахь удаагийн ургалтын цайг илэрхийлдэг.
4	Chuan 荈 ⁷	Зэрлэг цай, эсвэл боловсруулаагүй цайны навч
5	Ku 苦 ⁸	Гашуун, дээд зэрэглэлийн цай
6	Tu 荼 ⁹ .	Зэрлэг цай, эмийн ургамал, гашуун өвс ¹⁰
7	Cha 茶	Тан улсын “ <i>Цайны судар</i> ”-т “茶”[cha] гэх үгийг хэрэглэснээс энэ үг нь тогтвортой нэршил болж, өнөө болтол хэрэглэгдсээр байна

Тан улсаас өмнө хятадын “cha”-г 𣎵 [jia], 𣎵 [she], 茗 [ming], 荈 [chuan] гэсэн (Цю Зипин, 2021: 15) дөрвөн өөр ханзаар (Цю Зипин, 2021: 15) тэмдэглэн бичиж байсан хэмээн судлаачид үздэг (Жөү Жы Шю, 2022: 56). Түүнчлэн “*Цайны судар*”-т дурдсанаар 荼 (tu) гэх ханз нь анх Байлдаант улс (НТӨ 403-279)-ын үед хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд өнөөгийн “茶 [cha]” ханзтай утга нэгтэй боловч бичлэг, дуудлага нь бага зэрэг ялгаатай байв. Тан улсын үед “*Цайны судар*”-ын нөлөөгөөр “цай”-г илэрхийлэх өмнөх tu (荼) ханзын оронд cha (茶) ханз хэрэглэгдэж эхэлж, аажмаар бүрэн орлоод, өнөөг хүртэл үргэлжилсээр байна.

Газар тариалан эрхэлдэг хятадын ард түмэн цайг анх “анхилуун өвс” гэж таньсан болохоор 茶 [cha] ханзыг бичихдээ “өвс” (“艹” 草字头) гэх түлхүүр үгээр¹¹ эхлүүлсэн нь цайг Цайтан овгийн (*Tea plant*) *Camellia sinensis* цайны ургамлын мөнх ногоон бутлаг эсвэл жижиг модны төрөл зүйл гэдэг гарлыг нь тодорхойлсон явдал болно.



Бүдүүвч 1. 茶[cha] ханзыг задлах

⁵ Энэхүү мэдээлэл нь хятад ханзны анхны толь бичиг “Эр-я” -д анх тэмдэглэгдсэн байна.

⁶ Баруун Хань улсын сүүл үе (НТӨ 206 - НТ 9 дүгээр он)-д бичигдсэн тус толь бичигт Шу улсын урд нутагт цайг 𣎵 (she) гэж нэрлэж байсан гэх тэмдэглэл бий.

⁷ МЭӨ II зуунд Чин улсын судар (楚辞 *chu ci*)-т энэ үгийн тухай анх тайлбарласан байдаг.

⁸ Тан, Сүн улсын үед гашуун боловч дээд зэрэглэлийн цай гэж хэрэглэж байсан (苦茗 *ku ming*)

⁹ Чин улсын судар (楚辞 *chu ci*)-т МЭӨ III зуунд зэрлэг цай, эмийн ургамал гэсэн утгаар гардаг.

¹⁰ Ши Жин (诗经 *shi jing*)-д МЭӨ XI-VI зуунд гашуун өвс буюу горхи дагуу ургадаг байсан эмийн ургамлыг илэрхийлсэн.

¹¹ 草字头的字大多和植物有关，用作偏旁，俗称“草头”或“草字头”。“өвсний толгой” буюу “艹” гэсэн үндэс орсон ханз ихэвчлэн ургамалтай холбоотой байдаг. Уг хэсгийг хажуугийн нэмэлт болгон хэрэглэхийг ерөнхийдөө “草头” буюу “草字头” гэж нэрлэдэг.

Мөн түүнчлэн “хүн” (人) ханзыг “өвсний толгой” (++) болон “мод” (木)-ны дунд байрлуулсан байдаг нь цайг тарьж, ургуулах бүхий л үйл ажиллагаа цайны талбайд явагддаг тул хүн үргэлж байгаль, ургамлын дунд оршин хөдөлмөрлөж байдгийг илэрхийлдэг утгатай. Өөрөөр хэлбэл, энэ нь хүн байгаль дэлхийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өвс, ургамалтай адил шүтэлцээтэй, зохицон оршдог гэсэн утга агуулсан юм.

Эндээс, хятад, төвөд, тай язгуурын хэлний нэг салаа болох хятад хэл нь авиа, үг, хэлбэрийг нягт уялдуулан, утгыг цогцоор нь илэрхийлэх онцлогтой болох нь харагдана.

4. Монгол хэлэнд орсон цайны төрлийн үгс

Монгол хэлний “цай” хэмээх үг нь хятад гаралтай бөгөөд хятад хэлний “茶” [cha] гэх үгтэй дуудлага болон утгын хувьд төстэй байдаг. Үүнийг цайны нэршил анх хятад хэлнээс монгол хэлэнд нэвтэрснийг илтгэх тодорхой илрэл хэмээн үзэж болно. “Цай” хэмээх нэр томьёо хоёр хэлэнд хэрхэн хэрэглэдгийг доорх хүснэгтээр харуулбал илүү ойлгомжтой болно.

Хүснэгт 2. “Цай” болон 茶 [cha] гэх үгийн утга

д/д	Цайны утга	Монгол	Хятад
1	Анхилуун өвс	+	+
2	Тураг мод	+	+
3	Зарим ургамал, цайны модны навч	+	+
4	Боловсруулан савласан навчис	+	+
5	Цайны модны навчийг идээшүүлсэн унд	+	+
6	Зарим ургамлын хатаасан буюу боловсруулсныг усанд буцалгаж идээшүүлэн уух ундаа	+	+
7	Цай бүхий идээ хоол	+	—
8	Мөнгийг орлох нэгж	+	—

Эндээс үзэхэд, “цай” нь ургамлын навч, нахиа, ишийг төрөл бүрийн аргаар боловсруулан ууж хэрэглэдэг ундааны зүйл гэсэн үндсэн утгаараа хоёр хэлэнд ижил байна.

Монголчууд цайг хэрэглэх явцад түүний хэрэглээ амьдралын нөхцөл, хэв маягт зохицон өргөжиж, утга нь салаалсан байна. Тухайлбал, цай нь зөвхөн ундааны зүйл төдийгүй мөнгийг орлох нэгж болж, “цай бол мөнгө” гэсэн утгаар хэрэглэгдэх болсон байна. Мөн цай нь идээ, хоолыг төлөөлөх утгатай болж, хүнс тэжээлийн нэгэн чухал илэрхийлэл болон өргөжсөн байна.

Үүнээс гадна, хятадын цай нь монгол оронд анх орж ирэхдээ өөр өөр нэршлээр хэрэглэгдэж байсан түүхтэй. Үүнд:



Бүдүүвч 2. Монгол хэлэн дэх цайны нэршил

Монголчууд Чин улсын үед Хятадаас их хэмжээний цай оруулж ирж, малын арьс, ноос, мах зэргийг цайгаар солилцдог байсан түүхтэй. Манжийн төрөөс цайны худалдааг хатуу хянаж байсан тул тухайн үед орж ирсэн цайг “Манжийн цай”, “манж цай” гэж нэрлэдэг байжээ. Мөн монголын лам хуврагууд хурал хурахдаа ариун идээний нэг болгон цай уудаг бөгөөд цайг “Манж” буюу “манз” гэж хүндэтгэлийн утгаар нэрэлдэг байсан нь тухайн үеийн цайны хүндэтгэл, нэршил болохыг харуулна. Цай нь бие сэтгэлийг тэтгэх тансаг ундаа тул юуны урьд лам хувраг хүртдэг. “Лам нарын уухын дээд цай, амтатын дээд чихэр, идэхийн дээд боов” (Цэрэннадмид, 1999: 253) гэх мэтчилэн лам хуврагуудын ариун идээний нэг болсон цайг манж (бас “манз” гэж бичдэг) гэж хүндэтгэлтэйгээр нэрлэдэг байжээ.

Өнгөрсөн хугацаанд монголчууд хар цайг “чин” гэж нэрлэдэг байжээ. Энэ “чин” нь Чин улсын (清朝 [qing chao]), (清 [qing] “чин”) ханзаар тэмдэглэгдэх бөгөөд Чин улсын үед орж ирсэн шахмал ногоон цайг илэрхийлж байв. Харин сүүлдээ Хятадын Хүбэй (湖北 *hu bei*) мужийн 青茶 (*qing cha* “Чин цай”) гэх хар цай Монгол оронд түгээмэл болсон тул 清 (*qing* “Чин”) ханзнаас 青茶 (*qing cha* “Чин цай”) үүсэж, дуудлага ижил боловч бичлэг, утга нь ялгаатай болж хувирсан байна. Үүнийг монголоор “тунгалаг цай” гэж орчуулсан (Онгоодой, 1991: 95) бөгөөд өнөөг хүртэл дөрвөдүүд цайг мөн “чин” гэж нэрлэх нь хэвээр байна.

“Байхуу” гэдэг нь хятад гаралтай 白毫 [*bai hao*] гэх үг бөгөөд цагаан үслэг гадаргуутай залуу цайны нахиа, навчийг заадаг нэр томьёо юм. Энэ нь хятадын Фүжянь (福建 [*fu jian*]) мужийн гаралтай байхуу цай Монгол оронд орж ирснээр хэрэглээнд нэвтэрсэн бөгөөд улмаар оросууд монголчуудаар дамжин энэ төрлийн цайг хэрэглэх болж, “байховой” (*байховый чай*) хэмээх нэршил үүсжээ. Ийнхүү Монгол, Хятад, Оросын худалдаа, соёлын харилцааны нөлөөгөөр энэхүү цайг шууд “Байхуу” гэж нэрлэдэг болсон байна. Гэхдээ орчин үед “байхуу” нь олон улсын чанарын стандартад нийцсэн, дээд зэргийн цайг илэрхийлэх тусгай нэршил болж, анхны ерөнхий утгаасаа явцуурсан гэж үзэж болно.

“Гүнз” буюу “гонж” гэдэг нь “Тахилын цай” гэсэн утгатай (Цэрэннадмид, 1999: 253). Хятадын цайны түүхэнд, ялангуяа Манжийн үед төрийн дээдэст өргөн барьдаг өндөр чанартай тусгай цайг “贡茶” [*gong cha*] гэж нэрлэдэг байв. Тухайн үед Монголд өндөр чанартай, шахмал байдлаар боловсруулсан байхуу цай голчлон орж ирдэг байсан бөгөөд эдгээр цай нь ихэвчлэн тахилын зориулалттай тул зөвхөн лам хуврагууд хүртдэг байжээ. Үүнийг “сүм хийдэд лам хуврагууд оройн уншлагын дараа манз, гонзын алиныг ч амсдаггүй” гэх тэмдэглэлээс харж болно (Цэрэннадмид, 1999: 253). Иймээс “гүнз” буюу “гонж” нь хятад хэлэн дэх “贡茶” [*gong cha*] хэмээх үгээс гаралтай бөгөөд энэхүү цайны өндөр чанарыг онцлон тэмдэглэхийн тулд монгол хэлний авиа зүйн зохицуулан “гонз”, “гонж”, “гүнз” гэх мэтээр энгийн дуудах хэлбэрт оруулсан гэж үзэж болно.

5. Судалгааны үр дүн

Эндээс харахад, “цай”-ны олон нэршил нь тухайн цайны түүхэн гарал, хэрэглээний онцлогтой салшгүй холбоотой бөгөөд монголчууд эдгээр өндөр чанартай, талархал илэрхийлэх зориулалттай цайг өөрийн соёл, ёс заншилд нийцүүлэн нэрийдсэн гэж үзэж болно. Өнөө болоход “Манж” гэдэг нэршил нь цайтай холбогдох утгаа алдаж, зөвхөн Манж гүрнийг илэрхийлэх болсон бол бусад нэршил нь “цай” гэх ерөнхий ойлголтоос тодорхой цайны төрлийг заах утгатай болсон байна. Иймд “цай” хэмээх үг хятад хэлнээс монгол хэлэнд нэвтэрсэн боловч монгол соёлын онцлог, хэрэглээний хүрээнд утга нь өргөжин тэлж, шинэ агуулга, хэрэглээтэй болсон байна.

6. Дүгнэлт

Монгол, хятад хэлэнд хэрэглэдэг “цай” (монгол) болон “茶” [cha] (хятад) хэмээх үг нь анх ургамлын навчнаас гарган авсан, уух зориулалттай ундааг илтгэх шууд утгатай байсан боловч цаг хугацааны явцад энэ үгсийн хэрэглээ өргөжин, хэл зүй болон соёлын олон түвшинд утга салаалан хувирсан байна.

Хятад хэлэнд “茶” нь зөвхөн нэгэн төрлийн ундааг илтгэхээс гадна гүн ухаан, гоо зүй, ёс суртахуун, дотоод амгалан, хүндлэл, нөхөрлөл зэрэг сэтгэлгээний болон соёлын гүн гүнзгий утгыг агуулсан цайны соёл (茶文化)-ын төв ойлголт болон өргөжжээ. Харин монгол хэлэнд “цай” нь нүүдэлчин амьдралын өдөр тутмын хэрэглээ, зочин гийчний харилцаа, амны хишиг, элбэг дэлбэг байдал зэрэг ардын амьдралын хэв маяг, хүндлэл, бэлгэдлийн чанарыг илэрхийлсэн соёлын өв болон хөгжсөн байна.

Иймд “цай” хэмээх үг хятад хэлнээс монгол хэлэнд нэвтэрсэн боловч монгол соёлын онцлог, хэрэглээний хүрээнд утга нь өргөжин тэлж, шинэ агуулга, хэрэглээтэй болсон төдийгүй нийлмэл бүтцэт үгсийг үүсгэх суурь болж, утга зүйн хувьд зөвхөн нэгэн төрлийн ундааг бус, харин ч тухайн ард түмний сэтгэлгээний хэв шинж, амьдралын философи, үнэт зүйлсийг илэрхийлэгч соёлын цогц ойлголт болон өргөжин хөгжсөн нь анхаарал татахуйц соёл, утга зүйн үзэгдэл болж байна.

Ном зүй

А. Монгол хэлээр:

- Болд, Л.** (2008). *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*. Улаанбаатар: Адмон. [Bold, L. *Mongol khelnii delgerengüi tailbar toli*. [Comprehensive dictionary of the Mongolian language]. Ulaanbaatar: Admon. 2008.]
- Гантогтох, Г.** (2020). *Монгол нүүдэлчдийн тайлбар толь III*. Улаанбаатар: Мөнхийн үсэг. [Gantogtokh, G. *Mongol nüüdelchdiin tailbar toli. III*. [Mongolian nomads dictionary]. Ulaanbaatar: Mönkhin-Useg. 2020.]
- Лувсандорж, Д.** (2012). *Соёмбо нэвтэрхий толь: Хэл шинжлэл*. Улаанбаатар: Соёмбо. [Luvsandorj, D. *Soyombo nevterkhii toil: Khel shinjlel*. [Soyombo Encyclopedia: Linguistics]. Ulaanbaatar: Soyombo Press. 2012.]
- Норжин, Ц.** (1999). *Ц. Норжин. Nongrol kelen-ü toli*. Kökeqota: öbür mongvol-un arad-un keblel-ün qoriy-a. [Norjin, Ts. *Mongol khelnii toli*. [Dictionary of the Mongolian language]. Hohhot: People's Press Committee. 1999.]
- Онгоодой, Ч.** (1991). *Монгол идээн товчоо*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Ongoodoi, Ch. *Mongol ideen товчоо*. [A brief introduction to Mongolian food]. Ulaanbaatar: State Publishing House. 1991.]
- Отгонтуяа, Д.** (2017). *Соёлын үг хэллэгийн тавч тайлбар толь (С.Дуламын “Цагаан сарын бэлгэдэл” номын жишээгээр)*. Улаанбаатар: МУИС пресс. [Otgontuya, D. *Soyolyn üg khellegiin товч tailbar toli*. [A brief glossary of cultural terms (Based on the example of S. Dulam's book "The Symbols of the Lunar Month")]. Ulaanbaatar: Press of Mongolian State University. 2017.]
- Цэрэннадмид, Ж.** (1999). *Гал зул цай*. Улаанбаатар: ШУА. [Tserennadmid, J. *Gal zul tsai*. [Gal zul tea]. Ulaanbaatar: Mongolian Academy of Sciences. 1999.]

Б. Гадаад хэлээр:

- 严平, (1994). 茶文化. 中国国际广播出版社出版. (Янь Пин, (1994). *Цайны соёл*. Бээжин: Хятадын олон улсын өргөн нэвтрүүлгийн хэвлэлийн хороо) (Болд, 2008). [Jan Pin. *Zhongguo guoji guangbo chubanshe*. [Tea culture]. Beijing: China International Broadcasting Press Committee. 1994.]
- 冯时, (2022). 茶艺与茶文化. 华中科技大学出版社. (Фөн Шы, (2022). *Цайны урлаг ба цайны соёл*. Хүбэй: Хуа Жун шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хэвлэлийн хороо). [Fön Shy. *Huazhong keji daxue chubanshe*. [Tea art and tea culture]. Hubei: Hua Zhong University of Science and Technology Press Committee. 2022.]
- 屠幼英, (2014). 茶学入门. 浙江大学出版社. (Тү Ёу Ин, (2014). *Цайны судлалын удиртгал*. Ханьжоу: Жө Жян Их Сургууль). [Tü You In. *Zhejiang daxue chubanshe*. [Introduction to Tea Studies]. Hangzhou: Zhu Jiang University. 2014.]
- 陈椽, (1993). 论茶与文化. 中国农业出版社. (Чэнь Чуань, (1993). *Цай ба соёл*. Бээжин: Дундад улсын тариалангийн хэвлэлийн хороо). [Chen Chuan. *Zhongguo nongye chubanshe*. [Tea culture]. Beijing: Central Agricultural Press Committee. 1993.]
- 陈椽, (2018). 茶业通史. 中国农业出版社. (Чэнь Чуань, (2018). *Цайны ерөнхий түүх*. Бээжин: Дундад улсын тариалангийн хэвлэлийн хороо). [Chen Chuan. *Zhongguo nongye chubanshe*. [General history of tea]. Beijing: Central Agricultural Press Committee. 2018.]
- 周智修 (2022). 习茶精要详解. (Жөү Жы Шю (2022). *Цайны урлагийн сургалтын мөн чанарын дэлгэрэнгүй тайлбар*. Бээжин). [Jöü Jy Shyu. *Zhongguo nongye chubanshe*. [A detailed explanation of the nature of tea art training]. Beijing. 2022.]
- "茶经" 图说 (Цю Зипин, (2021). "*Цайны судар*"-ыг зургаар өгүүлэхүй. Бээжин). [Tsyu Zipin. *Zhongguo nongye chubanshe*. ["Tea Sutra" illustrated]. Beijing. 2021.]